

ЦӨМИЙН ЗЭВСЭГ БА ЭРЧИМ ХҮЧ

УДИРТГАЛ

20-р зуунд цөмийн эрчим хүчийг бий болгож, ашиглах болсон нь цэрэг армийн зориулалтаар цөмийг зэвсэг үйлдвэрлэж байсны үр дүнд бий болсон үйл явц юм. Энэ нь дэлхий даяар цөмийн технологийг үргэлжлүүлэн түгээн дэлгэрүүлэхийг зөвтгөж, цөмийн бөмбөгийг илүү хор хөнөөлгүй талаас нь харуулж, цөмийн эрчим хүч илүү хямд бөгөөд аюулгүй гэсэн худал ойлголтыг дэлгэрүүлсэн. Гэсэн хэдий ч цөмийн эрчим хүч нь уур амьсгалын хямралын буруу шийдэл бөгөөд цөмийн зэвсэг нь олон улсын энх тайван, аюулгүй байдал болон хүмүүнлэгийн үйлсэд хөнөөл учруулдаг. Цөмийн зэвсэг ба цөмийн эрчим хүчийг хоёуланг нь тэдгээрийн аюулгүй байдал, эрүүл мэнд ба хүрээлэн буй орчинд учруулах тоолж баршгүй их эрсдэлийнх нь хамтаар устгаж үгүй болгох нь олон улсын нэн тэргүүний зорилт байх ёстой. Шатах ашигт малтмал шиг тэдгээрийг нэн яаралтай устгах зайлшгүй шаардлагатай бөгөөд ингэснээр Хирошима, Нагасаки, Чернобыль ба Фукушимагийн аймшгийг дахин давтагдахаас сэргийлнэ.

АЛСЫН ХАРАА

Бидний алсын хараа нь цөмийн зэвсэг ба цөмийн эрчим хүчнээс ангид дэлхий ертөнцийг бий болгох болон ирээдүй хойч үеийг цацраг идэвхит хог хаягдалын аюултай түвшнээс чөлөөлөх явдал юм. Аюултай төдийгүй бохирдол ба цацраг идэвхит хог хаягдал үүсгэдэг цөмийн эрчим хүчийг бид аль болох түргэн устгах шаардлагатай байна. Оронд нь бид эрчим хүчний хангамж ба хэрэгцээ шаардлагын хоорондох зөрүүг нөхөхийн тулд салхины, нарны болон бусад сэргээгдэх эрчим хүчинд хөрөнгө оруулах ёстой.

ЗОРИЛТ

Хирошима ба Нагасакигийн цөмийн эмгэнэлт явдал, Чернобыль ба Фукушимагийн цөмийн гамшиг нь цөмийн асуудлыг онцгойлон авч үзэх шаардлагатайг онцлон тэмдэглэдэг. Тиймээс, Ногоонтнуудын үндсэн зорилт нь шинээр цөмийн эрчим хүчний станцууд барих ажлыг албан ёсоор хойшлуулахад уриалах, одоо байгаа цөмийн эрчим хүчний реакторуудын эрт үед нь ажиллагаанаас гаргах, цөмийн хаягдал шатаах зуух, хүнсний бүтээгдэхүүнийг цацрагаар ариутгах болон ураныг бүх зориулалтаар ашиглах зэрэг цөмийн хаягдал ашиглаж эсвэл бий болгодог технологиудыг устгах юм. Цаашилбал, Ногоонтнууд нь цөмийн зэвсэгээс ангид дэлхий ертөнцийг бий болгохын төлөө чармайн ажиллах болно.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

Нийт эрчим хүчний хэрэгцээ шаардлагыг багасгах бодлогууд дээр нэмээд Ногоонтнууд нь цөмийн эрчим хүч, цөмийн зэвсэг, түлш ба эрчим хүчний гинжин хэлхээнээс ангид дэлхий ертөнцийг бий болгохын төлөө цөмийн зэвсэг болон цөмийн эрчим хүчний станцуудад хориг тавьж, аюулгүй бөгөөд экологийн хувьд тогтвортой эрчим хүчний төрлүүдийг дэмжихийн тулд дотоодын болон олон улсын түвшинд ажиллах болно. Тиймээс Ногоонтнууд нь дараах арга хэмжээг авах болно -

Цөмийн эрчим хүч

- Цөмийн эрчим хүчийг дотоодын болон олон улсын хэмжээнд халах зорилтыг нэн тэргүүнд тавих
- Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээс цахилгаан ба дулааныг үр дүнтэй ашиглах замаар эрчим хүчний системд декарбонаци хийх болон шатах ашигт малтмал орлож, хангамжийн аюулгүй байдлыг хангах
- Цөмийн эх үүсвэрээс цахилгаан эрчим хүч үйлдвэрлэхийг болиулах, одоо байгаа бүх цөмийн эрчим хүчний станцуудыг ашиглалтаас гаргах болон шинэ цөмийн эрчим хүчний станц барих аливаа ажилд хориг тавих

Уран, тори ба цөмийн хаягдал

- Уран ба ториг олборлох ба экспортлохыг хориглох
- Уран ба торийн олборлолтын компанийг уран болон торийн олборлолтын талбайг нөхөн сэргээлт хийх хариуцлага хүлээлгэх, цацраг идэвхит төмрийн хаягдалыг аюулгүйгээр агуулах ба хянах стандартыг сахиулах
- Одоо байгаа цөмийн хаягдалыг удаан хугацаанд аюулгүйгээр агуулахад анхаарах болон шинэ цөмийн хаягдал бий болгохыг таслан зогсоох

Цөмийн Зэвсэг

- Цөмийн зэвсгийг байршуулдаг бүх байгууламжийг устгах
- Цөмийн зэвсэгээс ангид бүс, хотын захиргаа, боомтуудыг бий болгох
- Цөмийн зэвсгийн судалгаа, хөгжүүлэлт болон үйлдвэрлэлтийг зогсоох
- Цөмийн зэвсгийн үлдэгдэл хаягдалыг ашиглахгүй байх, устгах болон аюулгүйгээр найдвартай газар хадгалах
- Ураныг олборлох ба экспортлох болон цөмийн зэвсгийг түгээн дэлгэрүүлэх хоорондох холбоосыг таслах
- Улсын нутаг дэвсгэр дотор гадаадын цөмийн зэвсгийг байршуулахыг хориглох
- Цөмийн материалыг баяжуулах эсвэл зэвсэгжүүлэхтэй шууд холбоотой олборлолт, судалгаа, хөгжүүлэлт ба арилжааны технологиудын засгийн газрын санхүүжилтийг хориглох
- Гадаадын цөмийн зэвсгийн хөгжилд хувь нэмэр оруулдаг дотоодын үйлдвэрлэл, судалгаа ба бусад хувь нэмрийг хориглох
- Цөмийн зэвсгийг хориглох Иж Бүрэн Туршилтыг Хориглох Гэрээ болон бусад хууль зүйн хувьд хүчинтэй хэрэгслүүдийг соёрхон батлах

NPT ба Цөмийн Терроризм

- 1968 оны Цөмийн Зэвсгийг Үл Дэлгэрүүлэх Тухай Гэрээг (NPT) засварлаж, сайжруулах ингэснээр энэ нь газар дээрх хянан шалгалтыг нарийн явуулж, цөмийн материалуудыг зөвхөн энхийн зорилгоор ашиглахад анхаардаг.
- Цөмийн терроризмын аюулыг Цөмийн Материалын Биет Хамгаалалтын талаарх Конвенц болон Цөмийн Терроризмыг Хориглох Ажиллагааны талаарх Олон Улсын Конвенцтэй уялдуулан онцгойлон авч үзэх
- Олон улсын цөмийн зэвсэг үл дэлгэрүүлэх ба зэвсэггүйжүүлэх хэм хэмжээг хүчирхэгжүүлэх Цөмийн-Зэвсэгээс-Ангид-Бүс (NWFZ) шиг олон улсын механизмуудыг бий болгох болон энх тайван, аюулгүй байдалд чиглэсэн олон улсын хүчин чармайлтыг бэхжүүлэх

Олон улсад

- Цөмийн материалыг олон улсад тээвэрлэх ба арилжаалахад хориг тавих
- Сансарт цөмийн материал бүхий хөлгийг нисгэхийг хязгаарлах
- Бүс нутаг эсвэл олон улсад харьяалагдах далай тэнгисийн усанд цацраг идэвхит хаягдал хаяхад хориг тавих
- Олон улсын цөмийн хаягдал ба түлшийг импортлох ба дахин боловсруулахыг хориглох
- Уран торийн олборлолт ба арилжааг олон улсад зогсооход чиглэсэн ажиллагаа явуулах
- Цөмийн Зэвсгийг Хориглох Талаар НҮБ-ын Гэрээг үзэглэж, соёрхон батлах ажлыг дэмжих

Цөмийн Аюулгүй Байдал

- Цөмийн эрчим хүч нь олон улсын хүлэмжийн хийн ялгаралыг багасгах аюулгүй, цэвэрхэн, цагаа олсон, эдийн засгийн хэмнэлттэй эсвэл практик шийдэл биш гэдгийг ойлгож ухамсарлах
- Реакторуудын ажиллагааг зогсоож, байхгүй болгох хүртэл ослоос сэргийлэн цөмийн эрчим хүчний станцууд ба хангамжийн гинжин хэлхээг чанга зохицуулалтанд оруулах
- Одоо байгаа реакторуудыг халдлагаас хамгаалах
- Улс орон даяар цөмийн зэвсэггүйжүүлэх ажлаар дамжуулан цацраг идэвхит хаягдалын аюултай түвшнийг ирээдүй хойч үед хөнөөл учруулахгүй хэмжээнд хязгаарлах
- Ажлын байран дээрээ цацраг идэвхит бодист өртдөг ажилтнуудыг эрүүл мэндийн дэмжлэг ба нөхөн олговроор хангах
- Уран олборлолтын ажлын талбай, туршилт ба хайгуулын талбай, судалгаа ба үйлдвэрлэлтийн байгууламжууд ба хадгалалтын талбай зэрэг цацраг идэвхит материал агуулдаг бохирдсон талбайнуудыг нөхөн сэргээх
- Цөмийн аюулгүй байдал нь цөмийн технологи ашигладаг үндэстэн бүрийн хариуцлага гэдгийг ойлгож ухамсарлах
- Хүн, нийгэм ба хүрээлэн буй орчныг хамгаалахын төлөө хүчтэй, тогтвортой бөгөөд ил тод олон улсын цөмийн аюулгүй байдал ба хамгаалалтын тогтолцоог дэмжих
- Бүх цөмийн эрчим хүч үйлдвэрлэгчдийг өөрсдийнх нь бий болгосон цөмийн хаягдалд үүрд хариуцлага хүлээлгэх
- Цэрэг армийн ба иргэний зориулалттай цөмийн байгууламжуудад үйл ажиллагаа нь зогсож, устаж үгүй болох хүртэл хяналт тавих бие даасан сүлжээг бий болгох
- Цөмийн зэвсгийн туршилтын хохирогчдод нөхөн төлбөр олгох
- Цөмийн туршилтын талбайнуудыг нөхөн сэргээх
- Одоо байгаа цацраг идэвхит материалуудыг хамгийн аюулгүйгээр хадгалах талаарх бодлогыг мэргэжилтнүүдтэй хамтран гаргах ба газар доорх агуулахуудыг устгахыг эсэргүүцэх

Нөхөн Сэргээгдэх Цэвэр Нөөцүүд

- Нөхөн сэргээгдэгддэг, маш бага нүүрстөрөгчийн агууламжтай эх үүсвэрүүд болох эргийн ба эргийн бус салхины, далай тэнгисийн, нарны фото цахилгааны ба/эсвэл жижиг хэмжээний усан эрчим хүчин дээр голчлон суурилж цэвэр эрчим хүч үүсгэх ажлыг нэмэгдүүлэх
- Салхины, нарны, далай тэнгисийн болон жижиг хэмжээний усан эрчим хүч гэх мэт нөхөн сэргээгдэх цэвэр эрчим хүчний технологиудыг түлхүү хөгжүүлэхээр чармайх
- Нөхөн сэргээгдэх цэвэр эрчим хүч нь мөн хүрээлэн буй орчинд сөрөг нөлөөлөлтэйг онцлон, эдгээр нөлөөллийг бууруулах
- Нарны эрчим хүчийг өргөнөөр суурилуулах хямд, хортой бус нарны фото цахилгааны технологиудыг их хэмжээгээр үйлдвэрлэхээр чармайх
- Өртгийн өрсөлдөх чадварыг сайжруулахын тулд засгийн газрын байгууламжууд дээр суурилуулах зорилгоор засгийн газраас нарны эсийг томоохон хэмжээгээр худалдан авахыг дэмжих

Цөмийн Бохирдол

- Цацраг идэвхит туяанд өртөх тусам амьд биетүүдэд хуримтлагдах хөнөөлийн хэмжээг нэмэгдүүлдэг тул ирээдүйд хүрээлэн буй орчинд хүний бий болгосон цацраг идэвхит туяаг бий болохыг багасгах
- Нутгийн уугуул иргэдийн оршин суудаг нутаг дэвсгэр дээр ихэвчлэн явагддаг цөмийн бохирдол ба ураны олборлолтыг зогсоох
- Хүрээлэн буй орчны цацраг идэвхит бохирдолд тавих хүчирхэг, заавал биелүүлэх торгуулийг бий болгох

Бусад

- Эмнэлгийн мэргэжилтнүүдийг оношлогооны болон эмчилгээний ажилбарт цацраг идэвхит изотопыг хэтрүүлэн ашиглахыг багасгах
- Боломжтой үед эмнэлгийн цацраг идэвхит материалыг дахин боловсруулах болон богино настай эмнэлгийн хаягдалд зориулсан хадгалж байгаад устгадаг байгууламжуудыг бий болгох
- Цацраг идэвхит хаягдалыг газарт гүехэн булах болон үнс нурам болгож шатаахад хориг тавих
- Хамгийн сүүлийн үеийн стандарт болон шинжлэх ухааны хяналттай арга технологийг ашиглахаас бусад нөхцөлд цацраг идэвхит материалыг шинжлэх ухаанд ашиглахыг хязгаарлах

Лавлах холбоосууд:

<https://www.un.org/en/sections/issues-depth/atomic-energy/index.html>

<https://policy.greenparty.org.uk/ey.html>

<https://gp.org/cgi-bin/vote/proptdetail?pid=519>

<https://www.cagreens.org/platform/nuclear-contamination>

<https://politics.stackexchange.com/questions/48378/why-are-green-parties-so-often-opposed-to-nuclear-power>

https://www.reddit.com/r/GreenParty/comments/34zs7c/why_are_the_green_party_against_civil_nuclear/

<https://www.globalgreens.org/globalcharter-english#climate>

<https://www.facebook.com/thegreenparty/posts/nuclear-power-is-a-false-solution-to-the-climate-crisis-we-need-to-reduce-demand/175238475867684/>
<https://greens.org.au/policies/nuclear-and-uranium>
<https://indiagreensparty.org/policies/nuclear-and-uranium/>
<https://www.theguardian.com/environment/2012/jul/30/japan-green-party-nuclear-power>